# иргэдэд кино зураг авах зөвшөөрөл олгох журам

**МОНГОЛ УЛСЫН**

**ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ**

1999 оны 10-р сарын 22 өдөр Дугаар 226 Улаанбаатар хот

**Эрх шилжүүлэх, кино зураг авах хураамж,**

**үйлчилгээний хөлсний хэмжээг батлах тухай**

Монгол улсын Засгийн газрын 1996 оны 62 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын байгууллага, иргэдэд кино зураг авах зөвшөөрөл олгох журам"-ын 2:7 дугаар зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, иргэдээс мэргэжлийн кино зураг /уран сайхны, баримтат, дүрс бичлэгийн кино/ авахад зохих журмын дагуу зөвшөөрөл олгох эрхийг "Монгол кино нэгтгэл"-д шилжүүлсүгэй.

2. Монгол улсын нутаг дэвсгэрт гадаадын байгууллага, иргэдээм бүх төрлийн мэргэжлийн кино зураг авахад зөвшөөрөл олгосон хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай:

а/ бүрэн хэмжээний нэг ангит уран сайхны кино зураг авахад : 4.0-6.0 сая төгрөг

б/ бүрэн хэмжээний баримтад кино /40-50 минут/ зураг авахад: 1.5-3.0 сая төгрөг

в/ зураг авах обьект болон газрын онцлогоос шалтгаалж хэсэгчилсэн зураг авах: 0.5-1.0 сая төгрөг

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан соёлын сайдын 1996 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн "Кино зураг авах хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг батлах тухай" 121 дүгээр тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

САЙД А. БАТТӨР